



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 34 өдөр

Дугаар А/240

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдын Эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж шаардлагатай машин техник, тоног төхөөрөмжүүдийн хөрөнгө оруулалтыг газар дээр нь шийдвэрлэж, салбарын ажилтан, алба хаагчидтай уулзалт хийж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан салбарын бодлого, шинэтгэл түүнийг хэрэгжүүлэхэд чиг үүрэг бүхий байгууллагууд ямар үүрэгтэй оролцох, харьяа байгууллага, агентлагийн ажилтан алба хаагчдыг сургаж дадлагажуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажилласан ажлын хэсгийн зардалд 8 812 608 төгрөг, Ковид 19 цар тахлын голомтод ажилласан Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч, сувилагч нарт олгосон гарын бэлэгний зардалд 240 726 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 9 050 334 төгрөг /Есөн сая тавин мянга гурван зуун гучин дөрвөн/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/240 Ch

02 1418